



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/04

Арвайхээр

Г Коронавируст халдварт (ковид-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Улсын онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Коронавируст халдварт (ковид-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” 05 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Коронавируст халдварт (ковид-19)-ын эсрэг вакцины нэмэлт тунгаар вакцинжуулах тухай” А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын болон гадаадын 18-аас дээш насны иргэнийг сайн дурын үндсэн дээр коронавируст халдварт (ковид-19)-ын эсрэг вакцины 4 дүгээр тунгаар вакцинжуулах ажлыг 2022 оны 01 дүгээр сарын 10-наас эхлэн зохион байгуулсугай.

2. Коронавируст халдварт (ковид-19)-ын эсрэг вакцины дархлаа сэргээх нэмэлт тунгаар гурван тунд хамрагдсан, гурав дахь тунг тарьснаас хойш гурван сар өнгөрсөн болон вакцины үйлдвэрлэгчийн зааварт заасан хугацааг баримтлан шалгуурт нийцэх иргэнийг коронавируст халдварт (ковид-19)-ын эсрэг Пфайзер үйлдвэрийн “Комирнэти”, Синофарм/BIBP үйлдвэрийн “CorV” вакцинаас сонголт хийлгэн 4 дүгээр тунгаар вакцинжуулсугай.

3. Коронавируст халдварт (ковид-19)-ын эсрэг вакцины 4 дүгээр тунгаар вакцинжуулах арга хэмжээг удирдан зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт, мэргэжил арга зүйгээр ханганд, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннурдэв), Мэргэжлийн хяналтын газрын дарга (С.Дуламсүрэн), вакцины сургалт, сурталчилгааг эрчимжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (М.Золзая), вакцинжуулалтын үйл ажиллагааг зохион байгуулж, цэгийн тоог нэмэгдүүлэх, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журмын хэрэгжилтийг чанд мөрдөж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Сайнжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



6222 11 0007